

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/86/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Утас: 51-261628 Цахим хаяг: @audit.gov.mn Аудитор: Утас: 51- 261628 Цахим хаяг: @audit.gov.mn Сүлд-Аудит ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас:70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	10
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	12
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	13
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

дАДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТӨЯХТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар
МУИХ	Монгол Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ҮХХТ	Үл хөдлөх хөрөнгийн татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № 06/756
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ Овоо ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол Шивээ Овоо ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22,239.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй, нээлттэй тендер, шалгаруулалт, харьцуулалтын арга ашиглалгүй 746.6 сая төгрөгийн бараа материалыг шууд худалдан авсан, гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн эсэхэд тавих хяналт болон гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн;
- Бараа материалын дансанд он удаан жил болсон, ашиглах боломжгүй, технологи нь хоцрогдсон техник тоног төхөөрөмжийн 1846 нэр төрлийн 4,163.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл бүртгэлтэй;
- Нийгмийн даатгалын байгууллагад өгөх нийт 6,058 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй;
- Санхүүгийн тайлангийн богино хугацаат өр төлбөр хэсэгт зорилго нь тодорхойгүй 1,059.7 сая төгрөгийн өр төлбөрийн нөөц сангийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 47 дугаар зүйлийн 47.3, 48 дугаар зүйлийн 48.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1.3, 24 дүгээр зүйлийн 24.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “тохиолдсон байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Шивээ-Овоо ХК-ийн нүүрсний уурхайд олон улсын JORC кодын шаардлагад нийцүүлэн хайгуулын ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, CoalLog V.3.1 аргачилсан зөвлөмжид үндэслэн өрөмдлөг, хээрийн ажлын анхдагч баримтжуулалт, өгөгдлийн сангийн бүртгэл, боловсруулалтыг гүйцэтгэж дууссан байна. Уг ажлуудын үр дүнд Шивээ-Овоо ордын нөөц, баялгийн үнэлгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх JORC тайлангаар баталгаажуулах нөхцөл бүрдэх бөгөөд энэ нь цаашдын хөрөнгө оруулалт, техник-эдийн засгийн үндэслэл болон бүтээн байгуулалтын ажлын суурь баримт бичиг болох ач холбогдолтой байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 157 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Шивээ Овоо ХК нь толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК -аас жилийн 13 хувийн хүүтэй 100,517.1 сая төгрөгийн зээлийг авсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Төрийн өмчийн 18 хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гарган олон нийтэд нээлттэй худалдахаар шийдвэрлэсэн бөгөөд Шивээ Овоо ХК нь уг шийдвэрт хамрагдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 695 дугаар тогтоолоор эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж буй нүүрсний үнийг нэг тонн тутам 53,197 төгрөгөөр баталсан байсныг 2025 оны өдрийн 168 дугаар тогтоолоор 50,537 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,132,061,146.05	9,289,280,221.68
1.1.2	Дансны авлага	9,832,267,570.25	10,833,917,917.39
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		38,081,678.03
1.1.4	Бусад авлага	1,451,844,357.01	363,487,065.70
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	23,802,832,630.65	27,232,356,349.43
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	411,737,021.28	339,362,237.24
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	38,630,742,725.24	48,096,485,469.47
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	75,499,432,287.81	71,088,639,833.51
1.2.2	Биет бус хөрөнгө	149,109,157.36	103,121,637.04
1.2.7	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	627,169,395.40	627,169,395.40
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	76,275,710,840.57	71,818,930,865.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	114,906,453,565.81	119,915,416,335.42
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	60,436,874,789.23	58,905,059,670.06
2.1.1.2	Цалингийн өглөг	1,657,497,279.00	2,533,922,008.00
2.1.1.3	Татварын өр	16,698,379,234.32	1,289,647,948.55
2.1.1.4	НДШ-ийн өглөг	5,564,919,653.14	6,057,994,980.58
2.1.1.5	Богино хугацаат зээл	20,810,000,000.00	121,317,143,014.92
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	13,041,910.10	13,041,910.10
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	262,530,408.80	2,473,636,475.76
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	10,476,531,121.26	3,018,876,007.92
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	115,919,774,395.85	195,609,322,015.89
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	79,074,503,082.26	8,750,116,737.66
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	154,023,270.00	253,059,474.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	8,388,020,037.38	2,160,000,000.00
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	87,616,546,389.64	11,163,176,211.66
2.2	Өр төлбөрийн нийт дүн	203,536,320,785.49	206,772,498,227.55
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: Төрийн өмч	1,207,710,000.00	1,207,710,000.00
2.3.2	Хувийн өмч	134,190,000.00	134,190,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(89,971,767,219.68)	(88,198,981,892.13)
2.3.20	Эздийн өмчийн дүн	(88,629,867,219.68)	(86,857,081,892.13)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	114,906,453,565.81	119,915,416,335.42

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р Сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	111,170,380,301.47	125,706,617,144.56
3	Борлуулалтын өртөг	118,129,203,462.05	112,245,118,277.24
4	Нийт ашиг (алдагдал)	(6,958,823,160.58)	13,461,498,867.32
5	Түрээсийн орлого		
6	Хүүгийн орлого	22,184,789.30	14,542,064.96
7	Ногдол ашгийн орлого		
8	Эрхийн шимтгэлийн орлого		
9	Бусад орлого	223,472,793.74	137,423,279.35
10	Борлуулалт, маркетингийн зардал	2,029,086,673.66	2,292,533,293.97
11	Ерөнхий ба удирдлагын зардал	1,647,922,015.99	1,391,495,407.06
12	Санхүүгийн зардал	3,400,679,473.03	5,164,039,974.33
13	Бусад зардал	1,315,070,304.84	2,228,757,979.87
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	830,001,097.03	(319,236,305.77)
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	8,481,708.22	
16	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Хөрөнгө борлуулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
18	Бусад ашиг (алдагдал)		
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(14,267,441,239.81)	2,217,401,250.63
20	Орлогын татварын зардал	2,218,478.93	444,615,923.08
21	Татварын дараах ашиг (алдагдал)	(14,269,659,718.74)	1,772,785,327.55
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(14,269,659,718.74)	1,772,785,327.55
24	Бусад дэлгэрэнгүй орлого		
25	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
26	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
27	Бусад олз (гарз)		
28	Орлогын нийт дүн	(14,269,659,718.74)	1,772,785,327.55
29	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(77,614,487,123.02)	(76,272,587,123.02)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		1,912,379,622.08	1,912,379,622.08
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	(75,702,107,500.94)	(74,360,207,500.94)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
Тайлант үеийн цэвэр ашиг		(14,269,659,718.74)	(14,269,659,718.74)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(89,971,767,219.68)	(88,629,867,219.68)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	(89,971,767,219.68)	(88,629,867,219.68)
Өмчид гарсан өөрчлөлт			
Тайлант үеийн цэвэр ашиг		1,772,785,327.55	1,772,785,327.55
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(88,198,981,892.13)	(86,857,081,892.13)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	112,458,049,353.86	134,433,770,992.33
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	112,156,751,515.80	134,252,779,297.19
1.1.6	Бусад мөнгөн орлого	301,297,838.06	180,991,695.14
1.2	Мөнгөн зарлагын дүн	107,396,648,631.66	122,210,830,141.58
1.2.1	Ажиллагчдад төлсөн	15,517,943,292.30	17,548,579,834.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,950,000,000.00	5,560,388,672.56
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	25,379,895,198.19	25,373,850,220.33
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	45,287,524,098.39	34,800,820,035.14
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	679,753,077.77	1,063,774,331.49
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,502,903,193.28	25,559,539,477.81
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	11,078,629,771.73	12,303,877,570.25
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,061,400,722.20	12,222,940,850.75
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	21,872,068,391.13	19,365,153,991.39
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,068,528,348.74	18,728,648,761.58
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	2,803,540,042.39	636,505,229.81
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,872,068,391.13)	(19,365,153,991.39)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	24,000,000,000.00	27,262,641,054.20
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	24,000,000,000.00	27,262,641,054.20
3.2	Мөнгөн зарлагын дүн	6,780,728,371.73	13,963,208,837.93
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,332,183,616.00	7,346,473,796.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	3,110,000,000.00	6,184,974,316.38
3.2.5	Бусад	338,544,755.73	431,760,725.55
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,219,271,628.27	13,299,432,216.27
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	408,603,959.34	6,157,219,075.63
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,723,457,186.71	3,132,061,146.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,132,061,146.05	9,289,280,221.68

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			111,170,380.3	124,484,673.3	125,706,617.1	14,536,236.8	113.1	1,221,943.9	101.0
1	Нүүрс борлуулалтын орлого	м.төг	111,170,380.3	124,484,673.3	125,706,617.1	14,536,236.8	113.1	1,221,943.9	101.0
2	Нийт орлого	м.төг	112,254,520.7	124,594,673.3	125,858,582.5	13,604,061.8	112.1	1,263,909.2	101.0
3	Нийт зардал	м.төг	126,521,961.9	124,553,525.6	123,641,181.2	(2,880,780.7)	97.7	(912,344.4)	99.3
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	1,647,922.0	1,601,284.2	1,391,495.4	(256,426.6)	84.4	(209,788.8)	86.9
4	Татварын өмнөх ашиг	м.төг	(14,267,441.2)	41,147.7	2,217,401.3	16,484,842.5	(15.5)	2,176,253.6	5,388.9
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(14,269,659.7)	37,032.9	1,772,785.3	16,042,445.0	(12.4)	1,735,752.4	4,787.1
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	7,690,058.7	22,106,520.9	19,729,526.8	12,039,468.1	256.6	(2,376,994.1)	89.2
	а/ Орлогын татварт	м.төг	2,218.5	4,114.8	444,615.9	442,397.4	20,041.5	440,501.2	10,805.4
	б/ НӨАТ	м.төг	798,286.5	12,448,467.3	9,681,221.9	8,882,935.5	1,212.8	(2,767,245.4)	77.8
	в/ НДШ	м.төг	2,965,034.0	3,577,513.8	3,409,508.8	444,474.8	115.0	(168,005.0)	95.3
	г/ ХХОАТ	м.төг	651,300.8	2,109,499.5	2,125,383.2	1,474,082.4	326.3	15,883.7	100.8
	д/ ҮХХТ	м.төг	195,963.2	195,963.2	195,963.2	-	100.0	-	100.0
	з/ АТӨЯХТ	м.төг	6,848.8	10,376.2	13,631.9	6,783.1	199.0	3,255.7	131.4
	ж/ АМНАТ	м.төг	2,779,259.5	3,112,116.8	3,142,497.4	363,237.9	113.1	30,380.6	101.0
	и/ Бусад татварт	м.төг	291,147.5	648,469.4	716,704.5	425,557.0	246.2	68,235.1	110.5
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	13,041.9	-	13,401.9	360.0	102.8	13,401.9	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	429.0	487.0	436.0	7.0	101.6	(51.0)	89.5
9	Нийт цалингийн сан	м.төг	20,434,016.9	24,672,508.7	23,888,215.4	3,454,198.5	116.9	(784,293.3)	96.8
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,970.9	3,897.1	3,913.5	(57.3)	98.6	16.4	100.4
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.1	1.0	1.0	(0.1)	87.2	(0.0)	98.3
12	Хөрөнгө оруулалт	м.төг	25,646,763.0	13,451,933.4	12,868,077.7	(12,778,685.3)	50.2	(583,855.7)	95.7
13	Нийт авлага	м.төг	12,118,328.8	6,800,000.0	12,069,703.6	(48,625.3)	99.6	5,269,703.6	177.5
	Үүнээс: Найдваргүй	м.төг	(834,216.9)	(834,216.9)	(834,216.9)	-	100.0	-	100.0
14	Нийт өглөг	м.төг	203,536,320.8	183,800,000.0	206,772,498.2	3,236,177.4	101.6	22,972,498.2	112.5
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	115,919,774.4	111,977,500.0	195,609,322.0	79,689,547.6	168.7	83,631,822.0	174.7
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	87,616,546.4	71,822,500.0	11,163,176.2	(76,453,370.2)	12.7	(60,659,323.8)	15.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

“Шивээ-Овоо” ХК нь мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай уурхайчид болон дэвшилтэт техник технологид тулгуурлан, хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг үнэт зүйлээ болгон, “Байгаль орчинд ээлтэй, аюулгүй ажиллагаатай, өндөр бүтээмж бүхий уул уурхайн салбарын жишиг компани байх” эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Шивээ Овоо ХК-ийн хүрэн нүүрсний орд газар нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутаг дэвсгэрт Улаанбаатар-Бээжингийн олон улсын төмөр замын дэргэд далайн төвшнөөс 1180-1230 метрт оршдог бөгөөд орд нь зүүн хойноосоо баруун урагшаа сунаж тогтсон уртаараа 35 км, өргөнөөрөө 15 км хэмжээтэй, нийт 29,500 га талбайг хамран оршдог.

Шивээ Овоо ХК нь Монгол Улсын дотоодын цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн нүүрсний нийт хэрэгцээний 21.7 хувийг хангадаг бөгөөд гол хэрэглэгч нь Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК, Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны эрчим хүчийг үйлдвэрлэдэг Амгалан дулааны станц байна.

Шивээ Овоо ХК нь 13,419,101 ширхэг хувьцаатай ба хувьцааны 90 хувийг төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК, 10 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшдэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Шивээ Овоо ХК-ийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрлэл
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
- Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх
- Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

Шивээ Овоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 25/18 дугаар тогтоолоор зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Шивээ Овоо ХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон МУИХ, МУЗГ-ын холбогдох тогтоол, шийдвэр, компанийн удирдлагаас баталсан дүрэм журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль /нэмэлт өөрчлөлт/
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /нэмэлт өөрчлөлт/
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /нэмэлт өөрчлөлт/
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль/нэмэлт өөрчлөлт/.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсаны дагуу Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын алба нь нийт 7 орон тоотой байхаар шийдвэрлэсэн боловч 5 хүний орон тоогоор ажилласан байна. Мөн гүйцэтгэх захирлын 2025 оны А/80 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг шинэчлэн баталсан байна. Тайлант онд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд 27 хяналт шалгалтын ажлыг

төлөвлөсөн боловч 23 удаагийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар гүйцэтгэх захиралд илтгэх хуудсаар танилцуулж, холбогдох ажилтнуудад үүрэг даалгавар өгч, илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын албанаас Шивээ Овоо ХК-ийн “2024 оны техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал”-д шалгалт хийж урьдчилсан тайлан хүргүүлж, үйл ажиллагааг сайжруулах талаар 27 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 76 дугаар тогтоолоор батлагдсан Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нэгдсэн дансны жагсаалтгүй бөгөөд үйл ажиллагааны онцлогт бүрэн тохироогүй байна. Цаашид өөрийн үйл ажиллагаанд тохируулан дотооддоо сайжруулалт хийх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Шивээ Овоо ХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн баримталдаг бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,009.0 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,132,061.1	9,289,280.2	6,157,219.1
Авлага	11,284,111.9	11,235,486.7	(48,625.2)
Бараа материал	23,802,832.7	27,232,356.4	3,429,523.7
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	411,737.0	339,362.2	(72,374.8)
Эргэлтийн хөрөнгийн дүн	38,630,742.7	48,096,485.5	9,465,742.8
Үндсэн хөрөнгө	75,499,432.3	71,088,639.8	(4,410,792.5)
Биет бус хөрөнгө	149,109.2	103,121.6	(45,987.5)
Хөрөнгө оруулалт	627,169.4	627,169.4	0.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	76,275,710.9	71,818,930.8	(4,456,780.1)
Нийт хөрөнгө	114,906,453.6	119,915,416.3	5,008,962.7
Богино хугацаат өр төлбөр	115,919,774.4	195,609,322.0	79,689,547.6
Урт хугацаат өр төлбөр	87,616,546.4	11,163,176.2	(76,453,370.2)
Өр төлбөрийн нийт дүн	203,536,320.8	206,772,498.2	3,236,177.4

Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Эздийн өмч: Төрийн	1,207,710.0	1,207,710.0	0.0
Хувийн	134,190.0	134,190.0	0.0
Хуримтлагдсан ашиг	(89,971,767.2)	(88,198,981.9)	1,772,785.3
Эздийн өмчийн дүн	(88,629,867.2)	(86,857,081.9)	1,772,785.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	114,906,453.6	119,915,416.3	5,008,962.7

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, урт болон богино хугацаат өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн данс 9,289.3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 6,157.2 сая төгрөгөөр өссөн нь Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцаас 2,461.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр орж ирсэн болон нүүрсний борлуулалтын авлагууд төлөгдөж, төлөвлөсөн зарим зардлууд гараагүйгээс шалтгаалсан;
- Авлагын дансны үлдэгдэл 11,197.4 сая төгрөгт хүрч 48.6 сая төгрөгөөр буурсан нь нүүрс борлуулалтын авлага барагдуулсан;
- Бараа материалын үлдэгдэл 27,232.3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 3,429.5 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст дизелийн түлш болон тэсрэх материалын нөөцийг бүрдүүлсэн;
Тайлант онд 113,606.2 сая төгрөгийн нүүрс олборлож, 112,245.1 сая төгрөгийн нүүрсийг борлуулсан байна.
- Үндсэн хөрөнгийн данс нь 71,088.6 сая төгрөгт хүрч 4,410.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал 14,056.6 сая төгрөгөөр тооцсонтой холбоотой;
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 9,645.8 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан байна.
- Богино хугацаат өр төлбөрийн данс нь 195,609.3 сая төгрөгт хүрч 79,689.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд МУЗГ-ын 2025 оны 157 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-аас авсан 100,507.1 сая төгрөгийн зээл голлон нөлөөлсөн бөгөөд үүнээс гадна нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн өглөг 1,369.5 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлогын дүн 2,211.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх өглөг 8,989.5 сая төгрөгөөр, татварын өрийн үлдэгдэл 15,708.7 сая төгрөгөөр буурсан зэргээс мөн шалтгаалсан байна.
- Урт хугацаат өр төлбөрийн данс нь 11,163.2 сая төгрөгт хүрч 76,453.4 сая төгрөгөөр буурсан нь МУЗГ-ын дамжуулан зээлүүдийг төлсөнтэй холбоотой байна.
- Эздийн өмч 1,772.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 1,772.8 сая төгрөгийн ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шивээ Овоо ХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Шивээ Овоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 35 дугаар тогтоолын дагуу компанийн “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 146,583.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 146,366.0 сая төгрөгөөр, 217.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 13,451.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 25 дугаар тогтоолоор тодотгол оруулж нийт орлогыг 124,594.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 124,557.7 сая төгрөгөөр, 37.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар шинэчлэн баталсан байна.

Шивээ Овоо ХК нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан “Нэгдлийн хуулийн этгээдийн зорилтот түвшин, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах аргачлал”-ыг үндэслэн боловсруулж байна. Компанийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн батлагдсан маягт нь тухайн компанийн онцлогт тохирсон байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Шивээ Овоо ХК нь 2025 онд тодотгосон төлөвлөгөөгөөр 2,500.0 мянган тонн хүрэн нүүрс олборлон, 2,415 мянган тонныг борлуулах зорилготой ажилласнаас нүүрс олборлолт 2,464.2 мянган тонн, борлуулалт 2,428.7 мянган тонн болж, нүүрс олборлолтын төлөвлөгөө 98.6 хувь, нүүрс борлуулалтын төлөвлөгөө биетээр 101.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 125,858.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 123,641.2 сая төгрөгийн зардал гарган, 2,217.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллаж, 444.6 сая төгрөгийн орлогын албан татвар төлөхөөр тайлагнасан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 125,858.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,263.9 сая төгрөг буюу 1 хувиар давсан нь борлуулалтын үнийн өсөлт болон төлөвлөснөөс илүү нийлүүлэлт хийснээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 123,641.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 912.3 сая төгрөг буюу 0.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь төлөвлөсөн уулын ажлаа дутуу хэрэгжүүлснээс шалтгаалжээ. Хэмнэгдсэн томоохон зардлуудыг дурдвал тэсэлгээний зардал 286.1 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний зардал 705.0 сая төгрөг, цалин хөлсний зардал 784.3 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардал 264.2 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Удирдлагын зардал 1,391.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 13.1 хувиар хэмнэгдсэн нь цахилгаан эрчим хүчний зардал буурсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэлийн 90.8 хувь буюу 112,245.1 сая төгрөгийг борлуулсан нүүрсний бүтээгдэхүүний өртөг эзэлж байна. Тус байгууллага нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тооцоонд хамаарахгүй зардлыг шингээн бүртгэсэн нь нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртгийг хэтрүүлж, улмаар борлуулсан бүтээгдэхүүний өртгийг буруу тодорхойлоход хүргэж байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 7 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 12,868.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,772.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,735.7 сая төгрөгөөр илүү байгаа нь орлогын гүйцэтгэл өсч, зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 695 дугаар тогтоолоор 1 тонн нүүрсний борлуулалтын үнийг 14,207 төгрөгөөр нэмэгдүүлж 53,197 төгрөг болгосон, мөн 2025 оны 168 дугаар тогтоолоор 2,660 төгрөгөөр бууруулж 50,537 төгрөг болгосон ч өмнөх 2024 онтой харьцуулахад 1 тонн нүүрсний борлуулалтын үнэ 11,547 төгрөгөөр өссөн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/74 дүгээр тушаалаар “Компанийн бүтэц, орон тоо”-г шинэчилж нийт орон тоог 487 болгосон бөгөөд гүйцэтгэлээр 436 байна.
- Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/86 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.3.1-д “Компанийн ажилтан, албан тушаалтад хоолны хөнгөлөлт 60 хувиар, Хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад хоолны үнийн хөнгөлөлт 100 хувиар үзүүлнэ”

гэж заасан байна. Нэг хүний нэг өдрийн хоолны зардал нь хэвийн нөхцөлд ажиллаж байгаа хүнд 6,000 төгрөг, хүнд хортой нөхцөлд ажиллаж буй хүнд 10,000 төгрөгийн хөнгөлөлт олгодог байна. Тайлант онд 440.9 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийн зардал гарсан байна. Тус байгууллага нь унааны хөнгөлөлт олгодоггүй байна.

- Тайланд онд гадаад томилолтын зардалд 144.0 сая төгрөгийн зардал төсөвлөж гүйцэтгэлээр 53.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.
- Тус компани нь санхүүгийн үйл ажиллагаандаа Би Ти Солюшн ХХК-ийн 27.5 сая төгрөгийн анхны өртөгтэй Силикон программ хангамжийг, уул уурхайн үйл ажиллагаандаа "Mining tech" ХХК-ийн 84.7 сая төгрөгийн анхны өртөгтэй "Карлсон майнинг" программ хангамжийг ашигладаг байна.
- Тайланд онд 29 төрлийн сургалтад 123.6 сая төгрөгийн зардал төсөвлөж, гүйцэтгэлээр 29 төрлийн сургалтад 123.5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тухайн сургалтууд нь бүгд тухайн компанийн үйл ажиллагаатай холбоотой байна.
- Компанийн 35 жилийн ойн арга хэмжээний хүрээнд сэтгүүлийн зардалд 21.0 сая төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 20.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шивээ Овоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 35 тогтоолоор батлагдсан 2025 оны бизнес төлөвлөгөөнд үндэслэн Гүйцэтгэх захирлын А/16 дугаар тушаалаар 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 209 нэр төрлийн 126,552.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 82,825.8 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна. Үүнээс 48 нэр төрлийн барааны 746.6 сая төгрөгийн худалдан авалт нь ТБОНӨБАУХА тухай хуульд нийцэхгүй байна.

Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАУХА тухай хуулийн дагуу гүйцэтгэсэн эсэхэд аудитын төлөвлөгөөний дагуу нарийвчилсан горим сорил гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил хэсэгт нэгтгэн тайлагнасан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шивээ Овоо ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Шивээ Овоо ХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах хөрс хуулалтын хоцрогдол арилгах, бэлэн бүтээгдэхүүний өртгийн тооцооллыг зөв хийх, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу үнэн зөв зохион байгуулах, холбоотой талд өгөх зээлийн хүүгийн хэмжээг бууруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Б.Долгорсүрэн, Г.Баяржаргал, Г.Төрсайхан туслах аудитор Б.Баттогтох, Н.Цэрэндулам, Б.Хишигжаргал нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг Сүлд-Аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал ахлах аудитор Ч.Гүндбаяр нар, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор А.Даваадорж, аудитын менежер С.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Шивээ Овоо ХК 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 3/84 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 112,254.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,122.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/151 дүгээр тушаалаар Компанийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсан бөгөөд уг тушаалыг үндэслэн дэд захирлын 2 орон тоог бууруулсан байна. Мөн хууль тогтоомжид зааснаас өөр шагнал урамшуулал олгохгүй байх, илүү цаг олголтод хяналт тавих, аль болох ажилтныг биеэр амраах, бичиг хэрэг хөтлөлтийг дотоод сүлжээ, цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас хувилагчийн хорны зардлыг хэмнэх, байгууллагын цахилгаан дулаан, цэвэр усыг тоолууржуулах, цахилгаан дулаан усны хэрэглээг 10 хувиар хэмнэх арга хэмжээг авч ажиллажээ. Хэмнэлтийн арга хэмжээ авч ажилласны үр дүнд дараах зардлууд хэмнэгдсэн байна. Үүнд:

- Цалингийн зардал 784.3 сая төгрөгөөр;
- Цахилгаан эрчим хүчний зардал 458.2 сая төгрөгөөр;
- Дулаан, цэвэр усны зардлыг 149.8 сая төгрөгөөр;
- Бичиг хэргийн зардлыг 34.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,871.5 сая төгрөгийн 19 гүйлгээ, зардлын 21,198.9 сая төгрөгийн 76 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан байна. Мөн 299.1 сая төгрөгийн 13 гүйлгээг үнийн дүн зөрүүтэй буюу дутуу тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, гарсан зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-тай байгуулсан менежментийн гэрээний дагуу 11,213.5 сая төгрөгийн менежментийн төлбөрийн өр төлбөр бүртгэгдээд байна. Менежментийн төлбөрийг борлуулалтын орлогын 2 хувиар тооцохоор гэрээнд заасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тогтоолоор дамжуулан зургаан төрлийн үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байна. Эдгээр үйлчилгээний өртөг болон менежментийн төлбөрийн хэмжээ нь компанийн санхүүгийн чадавх, ашигт ажиллагаатай уялдахгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн”, Шивээ Овоо ХК-ийн дүрмийн 4.2.1-д “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, компаниас хувьцаа эзэмшигчдэд өгөх өгөөжийг байнга нэмэгдүүлэх үүрэг хүлээж ажиллана. Үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ”, “Эрдэнэс Монгол” ХХК-тай 2023 онд байгуулсан ЭМГЛ-58/МГ-01/20230613 дугаартай гэрээний 3.1-д “Толгой компани нь Төлөөлөн удирдах зөвлөл болон бусад шийдвэрээр дамжуулан дараах чиглэлийн хүрээнд менежментийн үйлчилгээг үзүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Толгой компанитай байгуулсан менежментийн гэрээний хэрэгжилт, үйлчилгээний агуулга, өртөг, төлбөрийн тооцооллыг компанийн санхүүгийн чадавх, ашигт ажиллагаа, эдийн засгийн үндэслэлтэй уялдуулан дахин хянаж, менежментийн төлбөрийн хэмжээг бодит үйлчилгээний гүйцэтгэл, үр өгөөжид үндэслэн тогтоох, үндэслэлгүй өр төлбөр үүсэхээс сэргийлэх, Төлөөлөн удирдах зөвлөлөөс уг гэрээний нөхцөл, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардлын дансад горим сорил хэрэгжүүлж бараа материал, үндсэн хөрөнгө, орлого,

зардал, өртөг, зээлтэй холбоотой асуудлуудыг илрүүлэн танилцуулж, үр дүнг нэгтгэн жилийн эцсийн тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн аудиттай холбоотой 5, санхүүгийн аудитын хүрээнд шалгасан нийцлийн аудитаар 3, нийт 8 зөрчил илрүүлж, 2.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 892.5 сая төгрөгийн 3 албан шаардлага, 7,883.5 сая төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүлж, 18.9 сая төгрөгийн 3 зөвлөмжийг өгсөн. Хариуцлага тооцох албан шаардлага бүрэн хэрэгжсэн, 3 зөвлөмжийн биелэлт 83.3 хувь, 3 албан шаардлага 3.5 хувийн гүйцэтгэлтэй, төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	2,357.2	0	0.0	0.0
2	Албан шаардлага	3	892,490.3	0	10,713.2	3.5
3	Зөвлөмж	3	18,946.6	1	15,156.8	83.3
4	Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	7,883,487.2	1	7,883,487.2	100.0
	Нийт дүн	8	8,797,281.7	3	7,911,147.0	45.1

/мянган төгрөгөөр/

Өмнөх аудитын хэрэгжээгүй шийдвэрийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

Төсөвт төвлөрүүлэх 2.4 сая төгрөгийн төлбөрийн акт хэрэгжээгүй бөгөөд Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 128/ШШ2025/0887 дугаартай шийдвэрийн дагуу тус төлбөрийн актыг хүчингүй болгосон байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах болон Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглагдаж байгаа 51,384.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,085 ширхэг хөрөнгийг дахин үнэлүүлэн, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Бараа материалын дансанд бүртгэлтэй, техникийн шинэчлэлтэй холбоотойгоор ашиглах шаардлагагүй болсон сэлбэгийг эргэлтэд оруулах, ашиглах зэргээр хөрөнгийн үр ашгийг сайжруулан, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалж байгаа зөрчлийг арилгах,
- Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай төлбөрийн урьдчилгаа тооцоог шийдвэрлээгүй зөрчлийг арилгах;
- Тайлант оны жилийн эцсийн үлдэгдэл дэх 102.8 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, хөрс хуулалтын ажлыг батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, технологийн дараалалтай уялдуулан зохион байгуулсан болон уурхайн нөхөн сэргээлт зэрэгт нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Мөн өмнөх аудитаар өгсөн хэрэгжээгүй шийдвэр, анхаарал татсан асуудлуудыг дээд шатны төсөв захирагч болон Төлөөлөн удирдах зөвлөл анхааралдаа авч шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-тай байгуулсан менежментийн гэрээний дагуу 11,213.5 сая төгрөгийн менежментийн төлбөрийн өр төлбөр бүртгэгдээд байна. Уг менежментийн төлбөрийг борлуулалтын орлогын 2 хувиар тооцохоор гэрээнд заасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тогтоолоор дамжуулан зургаан төрлийн үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байна. Эдгээр үйлчилгээний өртөг болон менежментийн төлбөрийн хэмжээ нь компанийн санхүүгийн чадавх, ашигт ажиллагаатай уялдахгүй байна.
- Богино хугацаат өр төлбөр, авлагын дүнгээс дунджаар 17 дахин өндөр байгаа нь байгууллагын богино хугацааны төлбөрийн чадвар, ирээдүйн санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлж байна. Толгой компаниас эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хямд эрсдэл багатай аргаар шийдэх, төлбөрийн чадварыг сайжруулах чиглэлээр шаардлагатай бодлого, зохицуулалт, арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна
- Бараа материалын дансанд бүртгэлтэй техникийн шинэчлэлтэй холбоотойгоор ашиглах шаардлагагүй болсон сэлбэгийг эргэлтэд оруулах, ашиглах зэргээр хөрөнгийн үр ашгийг сайжруулан, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалж байгаа зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,239.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 14.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 12,027.9 сая төгрөгийн 6 албан шаардлага, 881.8 сая төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага тус тус хүргүүлж, 9,315.2 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 22,239.0 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 21,116.5 сая төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант хугацаанд 1.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл авч байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, үр ашиггүй зардал гаргасан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Баруун Баянгийн Ширээ ХХК-тай байгуулсан ШО25-4/119 дугаар гэрээгээр 1 м³ уулын цул тээвэрлэлтийн хөлсийг 3,216 төгрөгөөр тооцохоор заасан боловч гүйцэтгэлийн актад 3,279 төгрөгөөр тооцож, 13.0 сая төгрөгийн илүү төлбөр олгосон нь гэрээний үнийг зөрчсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-д Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.1-д "гэрээний үнэ", 40 дүгээр зүйлийн 40.2-д "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно: 40.2.1-д "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", Шивээ Овоо ХК, Баруун Баянгийн Ширээ ХХК-тай байгуулсан ШО25-4/119 дугаартай гэрээний 2.4 -д "Гэрээний үнэ нь гэрээний хүчинтэй байх хугацаанд тохируулгагүй тогтмол байна" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үнийг баримтлаагүй илүү тооцож төлсөн зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд 746.6 сая төгрөгийн бараа, материалын худалдан авалтыг нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 -д "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина", 48 дугаар зүйлийн 48.2.7-д "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалтын нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй, гэрээ шууд байгуулсан зөрчлийг таслах зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд худалдан авсан бараа, материалыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн эсэхэд тавих хяналт болон гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 -д "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина", 48 дугаар зүйлийн 48.2.7-д "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын гэрээний хэрэгжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг сан дансны эхний үлдэгдлийн 1,059.7 сая төгрөгийн дүнг баталгаажуулах хангалттай зохистой нотолгоо байхгүй байна. Тухайн Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг сангийн данс нь яаж үүссэн нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг сан дансыг эхний үлдэгдэл анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Тус байгууллага нь тайлант оны эцэст 6,058.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг төлж барагдуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг төлж барагдуулаагүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглагдаж байгаа 51,384.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,085 ширхэг хөрөнгийг дахин үнэлүүлэн, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайланд онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн дүн нэмэгдэж 56,429.8 сая төгрөгийн дансны үнэтэй 2,205 ширхэг хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх талаар өгсөн өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

6. Хөрөнгийн удирдлагын зохистой менежмент хэрэгжүүлж ажиллаагүй, техник тоног төхөөрөмжийн хоцрогдол, насжилт зэргээс шалтгаалсан гэх 2003 оноос хойш хуримтлагдсан ашиглалтгүй 1,846 нэр төрлийн, нийт 4,163.7 сая төгрөгийн өртөг бүхий

сэлбэг хэрэгслийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.2-д “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Шивээ-Овоо ХК-ийн 2017 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Сэлбэг хэрэгсэл, бараа материалын захиалга гаргах, бэлтгэн нийлүүлэх, нөөц бүрдүүлэх, орлогод авах гаргах журам”-ын 4.5-д “Хагас бүтэн жилийн тооллогын дүнгээр компанийн зохистой нөөцийн бүрдүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж илүүдэлтэй эргэлт удаан байгаа хэсгийг худалдан борлуулж, эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг бууруулах...” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн удирдлагын зохистой менежмент хэрэгжүүлж ажиллаагүй, техник тоног төхөөрөмжийн хоцрогдол, насжилт зэргээс шалтгаалсан гэх ашиглагдахгүй сэлбэг хэрэгслийн үлдэгдэл хуримтлуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

7. Өмнөх оны аудитаар өгсөн нийт 881.8 сая төгрөгийн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлүүд арилаагүй байна. Үүнд:

- Бараа материалын дансанд бүртгэлтэй, техникийн шинэчлэлтэй холбоотойгоор компанид ашиглагдахгүй болсон 193 нэрийн 463.8 сая төгрөгийн сэлбэгийг эргэлтэд оруулах;
- Урьдчилж төлсөн дансанд бүртгэлтэй удаан олон жилийн насжилттай 326.2 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах;
- “Санхүүгийн тайланд тусгагдсан авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулах” албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант оны эцэст 91.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй албан тушаалтнуудад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Уулын ажилтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаагүйгээс 6,261,673 м³ хөрс хуулалтын хоцрогдол үүссэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 409 дүгээр тушаалаар батлагдсан “Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт”-д тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрс хуулалтын ажлыг батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, технологийн дараалалтай уялдуулан зохион байгуулж, үүссэн хөрс хуулалтын хоцрогдлыг бууруулах, арилгах тодорхой хугацаатай арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд дээд шатны байгууллагын чиглэлийн дагуу 640.6 сая төгрөгийн мод, бут бэлтгэсэн боловч уг арга хэмжээ нь тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, төсөв, төлөвлөлтийн сахилга хариуцлагыг зөрчсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5-д “төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц”, 20 дугаар зүйл 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, 24 дүгээр зүйлийн 24.1 “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн ямаар зардлын дээд хязгаарыг батлуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх, батлагдсан төсөв, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

3. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зардлын хуваарилалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын өртгийн тооцоонд их засварын зардал болон өмнөх онд төлсөн газрын төлбөр гэх мэт 479.3 сая төгрөгийн зардлыг оруулан тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3. “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2016 оны 409 дүгээр тушаалаар батлагдсан “Хайгуул ба олборлох үйл ажиллагааны стандарт”-ын 4.4.2.6.1-д “Бараа материалын өртөгт орох зардлууд” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “хэмжилт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэлийн өртгийн тооцоонд хамаарах болон үл хамаарах зардлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогод нийцүүлэн зөв ангилж, цаашид өртгийн хуваарилалтад тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах;

4. Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-аас жилийн 8.4–13.0 хувийн хүүтэй нийт 135,915.4 сая төгрөгийн санхүүжилтийн зээл авсан бөгөөд тайлант хугацааны эцсийн байдлаар 8,195.3 сая төгрөгийн хүүний төлбөрийн үлдэгдэлтэй байна. Зээлийн хүүгийн төлбөрийн үлдэгдэл хуримтлагдсан нь байгууллагын санхүүгийн зардал болон өр төлбөрийн дарамтыг нэмэгдүүлэх, улмаар төлбөрийн чадвар муудах, санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэл үүсгэж байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн”, Шивээ Овоо ХК-ийн дүрмийн 4.2.1-д “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, компаниас хувьцаа эзэмшигчдэд өгөх өгөөжийг байнга нэмэгдүүлэх үүрэг хүлээж ажиллана. Үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өрийн дарамтыг бууруулах зорилгоор толгой компаниас авч байгаа зээлийн хүүний хэмжээг бууруулах тал дээр арга хэмжээ авах, зээлийн хугацааг байгууллагын төлбөрийн чадвартай уялдуулан уртасгах талаар арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн хөрөнгөөр тайлант хугацаанд үр ашиггүй зардал гаргасан	1	1,110.0	1	1,110.0								
2	Баруун Баянгийн Шизэ ХХК-тай байгуулсан ШО25-4/119 дугаартай гэрээний үнийг илүү дүнгээр тооцож шилжүүлсэн	1	12,983.0	1	12,983.0								
3	Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалтын нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй, гэрээ шууд байгуулсан	1	746,582.8			1	746,582.8						
4	Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг дансыг эхний үлдэгдэл анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.	1	1,059,716.9			1	1,059,716.9						
5	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх талаар өгсөн өмнөх оны аудитын	1	-			1	-						

Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	зөвлөмжийг хэрэгжүүлээгүй												
6	Тайлант онд худалдан авсан бараа, материалыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн эсэхэд тавих хяналт болон гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн				1	-							
7	Тайлант оны эцэст 6,058.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг төлж барагдуулаагүй байна.	1	6,057,995.0		1	6,057,995.0							
8	Худалдан авах ажиллагааг уурхайн бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хийгээгүйгээс ашиглагдахгүй сэлбэг хэрэгслийн нөөц их хэмжээгээр үүсгэсэн.	1	4,163,680.2		1	4,163,680.2							
9	Өмнөх оны аудитаар өгсөн нийт 881.8 сая төгрөгийн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлүүд арилаагүй байна	1	881,777.1						1		2		
10	Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаагүйгээс 6,261,673 м³ хөрс хуулалтын хоцрогдол үүссэн байна.	1	-				1	-					
11	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө бэлтгэсэн.	1	640,550.0				1	640,550.0					
12	Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын тооцоонд өртөгт хамаарахгүй зардал оруулан тайлагнасан.	1	479,356.6				1	479,356.6					

Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

13	Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-аас жилийн 8.4–13.0 хувийн хүүтэй нийт 135,915.4 сая төгрөгийн санхүүжилтийн зээл авсан бөгөөд тайлант хугацааны эцсийн байдлаар 8,195.3 сая төгрөгийн хүүний төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	8,195,319.9					1	8,195,319.9				
	Дүн	13	22,239,071.5	2	14,093.0	6	12,027,974.9	4	9,315,226.5	1	2	-	-

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
1	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,871.5 сая төгрөгийн 19 гүйлгээ, зардлын 21,198.9 сая төгрөгийн 76 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан байна. Мөн 299.1 сая төгрөгийн 13 гүйлгээг үнийн дүн зөрүүтэй буюу дутуу тайлагнасан байна.	1	27,369,496.5			1	27,369,496.5						
1	Дүн	1	27,369,496.5			1	27,369,496.5						
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
1	Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-тай байгуулсан менежментийн гэрээний дагуу 11,213.5 сая төгрөгийн менежментийн төлбөрийн өр төлбөр бүртгэгдээд байна	1	11,213,467.3							1	11,213,467.3		
1	Дүн	1	11,213,467.3							1	11,213,467.3		
2	Нийт дүн	2	38,582,963.8			1	27,369,496.5	1	11,213,467.3				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 166/АДИ50053

Улаанбаатар хот

САГ-2026/86/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баруун Баянгийн Ширээ ХХК-тай байгуулсан ШО25-4/119 дугаар гэрээгээр 1 м³ уулын цул тээвэрлэлтийн хөлсийг 3,216 төгрөгөөр тооцохоор заасан боловч гүйцэтгэлийн актад 3,279 төгрөгөөр тооцож, 12,982,997.56 /арван хоёр сая есөн зуун наян хоёр мянга есөн зуун ерэн долоон төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийн илүү төлбөр олгосон нь гэрээний үнийг зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-д "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:" 39.3.1-д "гэрээний үнэ", 40 дүгээр зүйлийн 40.2-д "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно:", 40.2.1-д "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", Шивээ Овоо ХК Баруун Баянгийн Ширээ ХХК-тай байгуулсан ШО25-4/119 дугаартай гэрээний 2.4 -д "Гэрээний үнэ нь гэрээний хүчинтэй байх хугацаанд тохируулгагүй тогтмол байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээний үнээс илүү тооцон олгосон 12,982,997.56 /арван хоёр сая есөн зуун наян хоёр мянга есөн зуун ерэн долоон төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Батсуурь/, Ерөнхий нягтлан бодогч /У.Занабазар/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ч.ГҮНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ATA16037
0202081411

Z:\Akt\2026\0316 SAG-25.Docx

1526200197



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 167/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/86/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 1,110,000.00 /нэг сая нэг зуун арван мянга/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл авч байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант хугацаанд үр ашиггүй 1,110,000.00 (нэг сая нэг зуун арван мянган) төгрөгийн зардал гаргах шийдвэр гаргасан Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал асан Ц.Энхтүвшинээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүдэхийг Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Батсуурь/, Ерөнхий нягтлан бодогч /У.Занабазар/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 772/A0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/86/НА - СТА - ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Өмнөх оны аудитаар өгсөн нийт 881,777,064.81 /Найман зуун наян нэгэн сая долоон зуун далан долоон мянга жаран дөрвөн төгрөг наян нэгэн мөнгө/ төгрөгийн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлүүд арилаагүй байна. Үүнд:

- Бараа материалын дансанд бүртгэлтэй, техникийн шинэчлэлтэй холбоотойгоор компанид ашиглагдахгүй болсон 193 нэрийн 463,769,190.00 /дөрвөн зуун жаран гурван сая долоон үуун жаран есөн мянга нэг зуун ер төгрөгийн сэлбэгийг эргэлтэнд оруулах;
- Урьдчилж төлсөн дансанд бүртгэлтэй удаан олон жилийн насжилттай 326,239,597.10 /гурван зуун хорин зургаан сая хоёр зуун гучин есөн мянга таван зуун ерэн долоон төгрөг арван мөнгө/ төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах;
- “Санхүүгийн тайланд тусгагдсан авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулах” албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант оны эцэст 91,768,277.71 /ерэн нэгэн сая долоон зуун жаран найман мянга хоёр зуун далан долоон төгрөг далан нэгэн мөнгө/ төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй Шивээ Овоо ХК-ийн ахлах нягтлан бодогч /Л.Ундармаа/, ахлах нягтлан бодогч /Н.Соёлмаа/ нарт хуульд заасны дагуу сахилгын хариуцлага ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Батсуурь/-т хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 773/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/86/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,871,480,313.58 /таван тэрбум найман зуун далан нэгэн сая дөрвөн зуун наян мянга гурван зуун арван гурван төгрөг тавин найман мөнгө/ төгрөгийн 19 гүйлгээ, зардлын 21,198,892,640.74 төгрөгийн 76 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан, мөн 299,123,564.63 төгрөгийн 13 гүйлгээг үнийн дүн зөрүүтэй буюу дутуу тайлагнасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнийн дүн зөрүүтэй, хугацаа хоцроон байршуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ Овоо ХК-ийн захирал Г.Батсуурь, ерөнхий нягтлан бодогч У.Занабазар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.ГҮНДБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 774/АД150053

Улаанбаатар хот

САГ - 2026/86/НА - СТА - 704Г

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авсан бараа, материалыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн эсэхэд тавих хяналт болон гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.




Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 -д "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина", 48 дугаар зүйлийн 48.2.7-д "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын гэрээний хэрэгжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Батсуурь/, Хангамжийн хэлтсийн дарга /Ц.Эрдэнэбат/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ч.ГҮНДБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 775/АД 150053

Улаанбаатар хот

САГ - 2026/86/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд хийгдсэн худалдан авалтаас 746,582,767.40 /долоон зуун дөчин зургаан сая таван зуун наян хоёр мянга долоон зуун жаран долоон төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн бараа, материалын худалдан авалтыг нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулах шаардлагыг хангалгүйгээр шууд худалдан авах гэрээ байгуулсан нь худалдан авах ажиллагааны ил тод байдал, өрсөлдөөнийг хангах зарчимд нийцээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалтын нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Батсуурь/, Хангамжийн хэлтсийн дарга /Ц.Эрдэнэбат/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 776/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/86/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг сан дансны эхний үлдэгдлийн 1,059,716,941.41 /нэг тэрбум тавин есөн сая долоон зуун арван зургаан мянга есөн зуун дөчин нэгэн төгрөг дөчин нэгэн мөнгө/ төгрөгийн дүнг баталгаажуулах хангалттай зохистой нотолгоо байхгүй байна. Тухайн Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг сангийн данс нь яаж үүссэн нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг дансыг эхний үлдэгдэл анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Батсуурь/, ерөнхий нягтлан бодогч /У.Занабазар/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР,
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 777/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/86/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шивээ Овоо ХК нь өөрийн орлогын санхүүжилтээрээ өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлдэг бөгөөд эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг толгой компани болон банкнаас хүүтэй зээлэн авч санхүүжүүлж байгаагийн улмаас тайлант оны эцэст 6,057,994,980.58 /зургаан тэрбум тавин долоон сая есөн зуун ерэн дөрвөн мянга есөн зуун наян төгрөг тавин найман мөнгө/ төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг төлж барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Улсын төсөвт нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг төлж барагдуулаагүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ Овоо ХК-ийн захирал /Г.Батсуурь/, ерөнхий нягтлан бодогч /У.Занабазар/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 778/AD150053

Улаанбаатар хот

САГ -2026/86/КА -СТА -ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглагдаж байгаа 51,384,808,181.86 /тавин нэгэн тэрбум гурван зуун наян дөрвөн сая найман зуун найман мянга нэг зуун наян нэгэн төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,085 ширхэг хөрөнгийг дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайланд онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн дүн нэмэгдэж 56,429,834,031.19 /тавин зургаан тэрбум дөрвөн зуун хорин есөн сая найман зуун гучин дөрвөн мянга гучин нэгэн төгрөг арван есөн мөнгө/ төгрөгийн дансны үнэтэй 2,205 ширхэг хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх талаар өгсөн өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ Овоо ХК-ийн захирал Г.Батсуурь, ерөнхий нягтлан бодогч У.Занабазар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ч.ГҮНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ATA15007
9025031411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-44.Docx

1526181012



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 779/A0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/86/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээ Овоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгийн удирдлагын зохистой менежмент хэрэгжүүлж ажиллаагүй, техник тоног төхөөрөмжийн хоцрогдол, насжилт зэргээс шалтгаалсан гэх 2003 оноос хойш хуримтлагдсан ашиглалтгүй 1,846 нэр төрлийн, нийт 4,163,680,162.90 /дөрвөн тэрбум нэг зуун жаран гурван сая зургаан зуун наян мянга нэг зуун жаран хоёр төгрөг ерэн мөнгө/ төгрөгийн өртөг бүхий сэлбэг хэрэгслийн үлдэгдэл байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.2-д "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Шивээ Овоо ХК-ийн 2017 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Сэлбэг хэрэгсэл, бараа материалын захиалга гаргах, бэлтгэн нийлүүлэх, нөөц бүрдүүлэх, орлогод авах гаргах журам"-ын 4.5-д "Хагас бүтэн жилийн тооллогын дүнгээр компанийн зохистой нөөцийн бүрдүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж... илүүдэлтэй эргэлт удаан байгаа хэсгийг худалдан борлуулж, эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг бууруулах..." гэж заасантай тус тус нийцээгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эзвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Хөрөнгийн удирдлагын зохистой менежмент хэрэгжүүлж ажиллаагүй, техник тоног төхөөрөмжийн хоцрогдол, насжилт зэргээс шалтгаалсан гэх ашиглагдахгүй сэлбэг хэрэгслийн үлдэгдэл хуримтлуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Батсуурь/, ерөнхий нягтлан бодогч /У.Занабазар/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.ГҮНДБАЯР